






**Хог хаягдалыг булж, төгөл ой байгуулах технологи**

**Хог хаягдлыг булж, ойжуулалт хийх**

Сүүлийн жилүүдэд байгаль экологит сөргөөр нөлөөлж байгаа асуудлын нэг бол хог хаягдал юм. Хог хаягдлын 15-20 %, гялгар уутны 60-70%-ийг дахин ашиглах боломжтой байдаг. Иймээс бид хог хаягдалыг багасгах, тэдгээрийг зохистой ашиглах технологийг та бүгдэд танилцуулж байна. Тус технологи нь хогийн төвлөрсөн цэгийн талбайг багасгах, хог байсан хэсгийг булж, даран, өнгөн хөрсөнд мод тарьж ойжуулалтын талбай болгож байгаль орчныг нөхөн сэргээх, оршин суугчдын амьдрах орчин, нөхцлийг сайжруулах зорилготой юм. Одоогоор өргөн нь 100м, урт нь 2,3 км талбайд хогийг булж, дээр нь 16000 ш улиас, бургас тариалснаас амьдралт 90 хувьтай байна. Тус талбайд өөр төрөл, зүйлийн мод, сөөгийг тарьж, ургуулах бүрэн боломжтой юм. Уг технологи нь эхлээд хогийг ялгаад тодорхой хэмжээний талбайд 6-7метр гүн нүхийг нэгэн жигд ухаад дахин боловсруулагдахгүй хогоо хийн булж дээр нь 60-70 см эрүүл хөрсийг бэлтгэж хийнэ. Эрүүл хөрсийг бэлтгэхдээ бор шороо, бордоотой шороо гэх мэтээр үелэсэн байдлаар бэлтгэдэг. Бэлтгэж, зассан талбай дээрээ суулгацаа суулган тарина. Энэ технологийн усны асуудлыг Буянт голоос 18 км-ийн урттай хоолойгоор ус татаж, шуудуугаар услах замаар шийдвэрлэсэн байна. Хогийг булсан талбайд мод суулгац тарихад хөрс нь маш их үнсэрхэг байдаг учир усыг их хэмжээгээр шаарддаг. Иймээс тухайн технологийг нэвтрүүлэхдээ усалгааны асуудлыг өндөр түвшинд шийдсэн байхын зэрэгцээ бороо, цасны үерт өртхөөргүй газрыг сонгох шаардлагатай.

**1-р зургийн тайлбар :** Тухайн технологийг нэвтрүүлсний дараахи үе

**2-р зургийн тайлбар :** Технологийг нэвтрүүлэхээс өмнөх үе



**Байршил:** Ховд аймгийн Жаргалант сум

**Технологийн хамрах хүрээ:** 23 га

**Хөрс, ус хамгаалах арга**

**хэмжээний төрөл:** Менежмент

**Газар ашиглалтын төрөл:** Бэлчээр

**Уур амьсгал:** Хуурай, сэрүүн

**MONCAT мэдээллийн сангийн**

**нэрзүй:** ТА МОН-15

**Холбогдох арга барил:**

Бүртгэгдээгүй

**Технологийг нэвтрүүлсэн:** Ховд

аймгийн Жаргалант сумын

захирагчийн алба

**Технологийн талаарх мэдээллийг**

**өгсөн:** Т.Баатарзориг

**Технологийн бүртгэсэн:**

А.Хауленбек, Л.Мөнхнасан,

Ц.Ганчөдөр

**Он, сар, өдөр:** 2010.09.10

**Эмхэтгэгчдийн тайлбар:** Тус

технологи нь хогийг ялгаж зүй

зохистой ашиглах, аливаа хот, орон

нутгийн хог хаягдлын менежментийг

боловсронгуй болгох төдийгүй

ногоон байгууламжийн хамрах

хүрээг ихэсгэх гэх мэт байгаль,

экологийн хувьд маш их ач

холбогдлоо өгсөн технологи болж

чадсан байна. Иймээс үүнийг

цаашид бусад аймаг хотуудад


уламжлан дэлгэрүүлэх хийгээд

## Ангилал


### Газар ашиглалтанд тулгарч буй асуудал

Сүүлийн жилүүдэд ахуйн болон үйлдвэрийн хог хаягдэл ихээр нэмэгдэж байгаа боловч түүнийг багасгах, эрүүл ахуйн байдлыг сайжруулах тал руу чиглэгдсэн ажлууд ховор хийгдэж түүнийхээ хирээр ахуйн хог хаягдлын эзлэх талбай тэлж байна.

### Газар ашиглалт      Уур амьсгал      Доройтлын хэлбэр      Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл



Бэлчээр




Хуурай сэрүүн




Биологийн доройтол: биомасс буурсан



Усны доройтол: хөрс чийгээр дутагдсан



Ургамлын: олон наст тарих, үр цацах



Менажмент:

### Техник үүрэг/үзүүлэх шууд нөлөө:


- Хөрсийг бэхжүүлэнэ
- Ургамалан нөмрөг сэргэнэ
- Ургамлын төрөл зүйл нэмэгдэнэ

### Техник үүрэг/үзүүлэх дам нөлөө:


- Зэргэлдээ талбайд үзүүлэх дам сөрөг нөлөө буурана
- Биомасс нэмэгдэнэ

## Байгаль орчин


### Жилийн дундаж хур тунадас(мм)




### Өндөршил (д.т.д м)



### Гадаргын хэлбэр      Налуужилт (%)




### Хөрсний гүн (см)



Ургамал ургах хугацаа: 120-130 хоног  
Хөрсний үржил шим: Дунд зэрэг  
Хөрсний бүтэц: Сийрэг  
Гадаргын чулуурхаг байдал: Дунд  
Хөрсний гадаргын органик бодисын хэмжээ: Бага  
Хөрсний ус нэвтрүүлэх чадвар: Сайн  
Хөрсний элэгдэл эвдрэлд өртөх байдал: Хүчтэй


Агаарын жилийн дундаж температур:  $-0.5\text{ }^{\circ}\text{C}$   
Хамгийн их/бага температур:  $+35/-48$   
Агаарын хамгийн их/бага даралт: 4 сард 901.5/мб/, 3сард 832.2 /мб/  
Агаарын жилийн дундаж даралт: 860.5 /мб/  
Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа: Жилд 27942 цаг, 5-6 р сар буюу хамгийн ихдээ 290 цаг, 12-р сар буюу хамгийн багадаа 142 цаг байдаг байна.

### Нэг өрхөд ноогдох бэлчээрийн талбай (га)



Газар ашиглалтын эрх: Нээлттэй  
Газар эзэмшсэн эсэх: Төрийн/нийтийн  
Зах зээлийн төрөлжилт: Холимог: амь зуулга/арилжаа наймаа  
Шаардагдах техник мэдлэг түвшин: Их: мэргэжилтэн  
ХАА-аас гадна олох орлого, түүний ач холбогдол: 70%

Суурин/нүүдэлчин: Суурин  
Ядуурлын түвшин: Бага  
Ажилгүйдлийн түвшин: Дунд  
Нийгмийн зохион байгуулалт: Сайн



Техникийн зураг:

1.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, үнэ өртөг**

Байгуулагдах үйл ажиллагааны дараалал	Байгуулахад гарах зардал /1 \$-ыг 1420 төгрөгөөр бодов/		
	Хөрөнгө оруулалт	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Нэгэн жигд хэмжээгээр нүх ухах	Нүх ухаж, хог дарах	1056	0%
2. Хог хаягдлыг ялгах	Хогийг дарж түрэх	1056	0%
3. Хог хаягдалыг дарж булах	Эрүүл хөрсөөр сэргээх	352	0%
4. Эрүүл хөрсөөр сэргээх	Шон суулгах	1760	0%
5. Хамгаалалтын хашааг барих	Хамгаалалтын тор татах	2464	0%
6. Усны асуудлыг шийдвэрлэх	Усны труба татах	2464	0%
7. Суулгацыг суулгаж, тарих	Усны суваг татах	1760	0%
	Суулгац худалдан авах	1056	0%
	Тээврийн хөлс		0%
	Ажилчдын зардал	1056	0%
	Нийт		0%

Хүн хүчний өртөг	Бусад хөрөнгө оруулалт						
<table border="1"> <tr><td>Өндөр</td></tr> <tr><td>Дунд</td></tr> <tr><td>Бага</td></tr> </table>	Өндөр	Дунд	Бага	<table border="1"> <tr><td>Өндөр</td></tr> <tr><td>Дунд</td></tr> <tr><td>Бага</td></tr> </table>	Өндөр	Дунд	Бага
Өндөр							
Дунд							
Бага							
Өндөр							
Дунд							
Бага							

Засаж, сайжруулах ажил	Урсгал зардал 1жилд /га-аар/	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Хамгаалалтын хашааг засаж, засварлах	Гарах зардал		
	Хамгаалалтын хашааг засаж, засварлах	35	0%
	НИЙТ	35	0%

**Үнэлгээ**

Үр ашиг /газар ашиглагчаас хамаарсан өртөг	Газар ашиглагчийн үзэж байгаагаар олсон ашиг	Богино хугацаанд	Урт хугацаанд
	<b>Анх байгуулахад зарцуулагдсан зардалтай харьцуулахад олсон үр ашиг</b>	Машсөрөг	Эерэг
	<b>Урсгал зардалтай харьцуулахад олсон үр ашиг</b>	Машсөрөг	Эерэг

Технологийн нөлөөлөл	
<b>Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн үр ашиг</b> + + + Хог хаягдлыг ялгаж, төрөлжүүлэн эргэж үйлдвэрлэлд ашиглах боломж нээгдсэн	<b>Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн алдагдал</b> байхгүй
<b>Нийгэм соёлын үр ашиг</b> + + + Эрүүл мэндийн байдал + + + Доройтлын талаарх мэдлэг сайжирсан	<b>Нийгэм соёлын алдагдал</b> байхгүй
<b>Экологийн үр ашиг</b> + + + Ургамлан нөмрөгийн төрөл зүйл нэмэгдсэн + + + Гадаргын байдал сайжирсан + + + Биомасс нэмэгдсэн + Хөрсний өнгөн давхарга сайжирсан	<b>Экологийн алдагдал</b> байхгүй
<b>Дам үр ашиг</b> + + +	<b>Дам сул тал</b> байхгүй

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах	Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах
Хог хаягдалгүй болно → тус технологийг өргөн дэлгэр хэрэглэх, өөр бүс нутагт хэрэгжүүлэх	Хөрөнгө их хэмжээгээр шаардагдана → хогийг ялгаж боловсруулах үйлдвэрт нийлүүлж зарцуулагдсан зардлаа нөхөх, мэргэжлийн түвшний удирдах байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж дэмжлэг туслалцаа авах
Ногоон байгууламжийн талбай нэмэгдэнэ → тарих мод, сөөгний зүйлийн бүрдлийг нэмэгдүүлэх	Тарьц суулгаж байгаа талбай нь үнс, элс ихтэй хөрс учраас ус их шаарддаг → дуслын услын систем, бороожуулагч гэх мэтийг ихээр ашиглах
Хогийг ялгаж зүй зохистой ашиглах боломж бүрдэнэ → ялгасан хог, хогон бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг байгуулах	
Ард иргэд байгалиа хамгаалах, цэвэр цэмцгэр байлгах мэдлэгийг олж авсан → олон нийтэд нээлттэй түгээж, сурталчилах, түүний ач холбогдолыг тайлбарлах	

Холбоо барих байгууллага: Швейцарийн хөгжлийн агентлаг Цөлжилтийн сааруулах төсөл  
 Вебсайт: [www.greenmongolia.mn](http://www.greenmongolia.mn)  
 ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв  
 Вебсайт: [www.mas.ac.mn](http://www.mas.ac.mn) , [www.drc.mn](http://www.drc.mn) , [www.moncat.mn](http://www.moncat.mn)